



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/133

Есөнбулаг сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх  
ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэг, 21 дүгээр зүйл, 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 28-ний А/16 тоот тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2026 оны 03 дугаар сарын 03-ны А/30 тоот тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажлыг аймгийн хэмжээнд 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.

3. Мал амьтныг халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай хамтран, ажиллах хүч, хашаа хороо, тээврийн хэрэгслээр хангаж, тогтоосон цаг хугацаанд шуурхай зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах биобэлдмэл, вакцин, эм урвалжийг хугацаанд нь татан авч хуваарилах, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж, ажлын явцыг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор, үр дүнг 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус тус Засаг даргад тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Р.Бүрэнбаясах)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзоригт)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

D:Ajil, zahiramjZax ZD 2025

8200010712

Аймгийн Засаг даргын 2026 оны  
03 дугаар сарын 13-ны өдрийн АЗ дүгээр  
захирамжийн хавсралт

МАЛ ЭМНЭЛГИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА  
ХЭМЖЭЭНД ХАМРАГДАХ МАЛЫН ТОО

Сумын нэр	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдах малын тоо, төрлөөр				Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо
	Бод	Бог	Амьтан	Нийт мал, амьтан	Нийт мал, амьтан
Алтай	2400	5340	260	8000	20600
Баян-Уул	13300	37270	330	50900	61963
Бигэр	23200	88000	200	111400	39463
Бугат	2100	15100	500	17700	54700
Дарив	10000	36020	180	46200	86620
Дэлгэр	2600	22830	170	25600	123320
Жаргалан	26100	23269	631	50000	91330
Тайшир	3600	14000	200	17800	53500
Тонхил	1100	12130	370	13600	76800
Төгрөг	3020	9370	330	12720	37860
Халиун	6400	24600	300	31300	96450
Хөхморьт	21050	21980	220	43250	112920
Цогт	3000	16690	310	20000	147565
Цээл	2700	20541	259	23500	82400
Чандмань	3100	12420	280	15800	61029
Шарга	13500	27210	290	41000	89200
Эрдэнэ	4300	11940	260	16500	19101
Есөнбулаг	5580	25590	910	32080	93812
Нийт	147050	424300	6000	577350	1348633

